



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

2015 ОНЫ IV УЛИРАЛ

**СЗХ-НЫ ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

**УЛААНБААТАР ХОТ 2016 ОН**

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ****1. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА, ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:****1.1. Нийт арилжаа:**

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаа явагдаж, 125 компанийн 35.8 сая ширхэг хувьцааг 30.5 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны анхдагч зах зээлийн 54 удаагийн арилжаагаар 5.4 сая ширхэг үнэт цаасыг 510.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 52.3 мянган ширхэг үнэт цаасыг 5.1 тэрбум төгрөгөөр, мөн компанийн бонд /“Эрчим Инженеринг” ХХК/-ын анхдагч зах зээлийн арилжаагаар 50.0 мянган ширхэг бондыг 500.0 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 546.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хийгдсэн нийт гүйлгээний 5.58%-ийг хувьцааны, 93.39%-ийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны, 0.93 %-ийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааны, 0.09%-ийг компанийн бондын арилжааны үнийн дүн тус тус эзэлж байна. Үүнийг хүснэгт-1 болон график-1-аар харуулав.

Хүснэгт 1

Үнэт цаасны төрөл		Хийгдсэн арилжааны тоо	Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум.төг/
Хувьцаа	Энгийн	197	14.6	27.3
	Багц		21.2	3.1
ЗГҮЦ	Анхдагч	54	5.4	510.3
	Хоёрдогч		0.052	5.1
Компанийн бонд	Анхдагч	1	0.05	0.5
	Хоёрдогч			
<b>Нийт</b>		<b>252</b>	<b>41.30</b>	<b>546.4</b>

График-1



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 163.9 мянган ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Хүснэгт 2

№	Он	Нийт арилжаа /сая.төг/	Өөрчлөлт +/-	Өөрчлөлт дахин
1	2010 он	92,873.1	+453,567.9	5.9
2	2011 он	350,235.9	+196,205.1	1.6
3	2012 он	145,056.7	+401,384.3	3.8
4	2013 он	98,597.2	+447,843.8	5.5
5	2014 он	60,358.7	+486,082.4	9.1
6	2015 он	546,441.1	-	-

Биржийн нийт арилжааны хэмжээг 2010 оны эцэстэй харьцуулахад 453.6 тэрбум төгрөгөөр буюу 5.9 дахин, 2011 оны эцэстэй харьцуулахад 196.2 тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин, 2012 оны эцэстэй харьцуулахад 401.4 тэрбум төгрөг буюу 3.8 дахин, 2013 оны эцэстэй харьцуулахад 447.8 тэрбум төгрөгөөр буюу 5.5 дахин, 2014 оны эцэстэй харьцуулахад 486.1 тэрбум төгрөгөөр буюу 9.1 дахин тус тус өсч, 546.4 тэрбум төгрөгболсон байна. Ийнхүү арилжааны үнийн дүн өсөхөд ЗГҮЦ-ны арилжааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар явуулах болсон нь нөлөөлжээ. Нийт арилжааны хэмжээг өмнөх онуудтай харьцуулан дараах графикаар харуулав.

График-2 /сая.төг/




## 1.2. Хувьцааны арилжаа:

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 197 удаагийн хувьцааны арилжаа явагдаж, нийтдээ 125компанийн 35.7 сая ширхэг хувьцааг 30.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны дундаж ханш 853.7 төгрөг байсан байна. Хувьцааны арилжааны 10.3% буюу 3.1 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 89.7% буюу 27.4 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон гаргасан “Бинсэ” ХК-ийн 150.8 мянган ширхэг хувьцааг 112.2 сая төгрөгөөр, “БиДиСек” ХК-ийн 189 ширхэг хувьцааг 405.6 мянган төгрөгөөр, “Эрчим инженеринг” ХХК-ийн 50 мянган ширхэг “Эрчим” бондыг 500 сая төгрөгөөр, “МИК Холдинг” ХК-ийн 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум төгрөгөөр тус тус анхдагч зах зээлд арилжсан байна.

График-3



№	Он	Хувьцааны арилжааны үнийн дүн	Өөрчлөлт /төгрөг/ +/-	Өөрчлөлтийн хувь	Ширхэг сая	Дундаж үнэ /төгрөг/
1	2010 он	62,873,141,553.0	-32,395,744,494.3	-51.5	-	-
2	2011 он	109,110,768,611.0	-78,633,371,552.31	-72.1	122.8	511.9
3	2012 он	144,746,456,537.3	-114,269,059,478.56	-78.9	133.7	1,082.6
4	2013 он	97,586,883,646.5	-67,109,486,587.77	-68.8	65.8	1,483.1
5	2014 он	24,241,804,663.1	+6,235,592,395.56)	+25.7	51.7	468.8
6	2015 он	30,477,397,058.7	-	-	35.7	853.7

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2015 оны эцсийн байдлаарх нийт хувьцааны арилжааны хэмжээг 2010 оны эцэстэй харьцуулахад 32.3 тэрбум төгрөгөөр буюу 51.5 хувиар, 2011 оны эцэстэй харьцуулахад 78.6 тэрбум төгрөгөөр буюу 72.1 хувиар, 2012 оны эцэстэй харьцуулахад 114.3 тэрбум төгрөг буюу 78.9 хувиар, 2013 оны эцэстэй харьцуулахад 67.1 тэрбум төгрөгөөр буюу 68.8 хувиар тус тус буурсан ба харин 2014 оны эцэстэй харьцуулахад 6.2 тэрбум төгрөгөөр буюу 25.7 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна. Нийт хувьцааны арилжааны хэмжээг өмнөх онуудтай харьцуулан дараах графикаар харуулав.

График-4 /төгрөг/




Хувьцааны арилжааны нийт хэмжээ 2012 оноос хойш 2013, 2014 онуудад буурсан үзүүлэлттэй байсан ба 2015 оны эцсийн байдлаар 2014 оныхоос өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд “МИК холдинг” ХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан 1.6 сая ширхэг 19.5 тэрбум төгрөгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар дамжуулан анхдагч зах зээлд дээр арилжаалсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Гэвч “МИК холдинг” ХК-ийн хувьцааны арилжааг оруулахгүйгээр хувьцааны арилжааны зах зээлийн ерөнхий үзүүлэлтийг авч үзвэл арилжигдсан хувьцааны нэр төрөл цөөн, арилжааны хэмжээ бага хэвээр байгаа ба үүнд голчлон гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд манай орны бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, дийлэнх хувьцаат компаниудын засаглал сул, төвлөрөл өндөр, тайлагналын ил тод тогтолцоо төлөвшөөгүй, зах зээлийн хөрвөх чадвар доогуур байгаа нь нөлөөлж байна.

Мөн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомсоос гадна хувьцаа худалдан авахаасаа илүүтэйгээр банкны хадгаламж, Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө байршуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул хэвээр байгаа нь давхар нөлөөлж байна.

**Хувьцааны хэмжээг 2014-2015 онуудын байдлаар харьцуулан сараар харуулав**

График-5 /тэрбум.төг/



**1.3.Хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ:**

Хөрвөх чадварын түвшин нь зах зээлд арилжигдаж буй үнэт цаасны эргэлтийг хэмжигч үзүүлэлт бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудын хувьд дээрх үзүүлэлт 0.80-0.90 хувь байдаг ба манай орны хувьд хөрвөх чадварын түвшин 2015 оны жилийн эцсийн байдлаар 0.024 хувь байгаа нь хувьцааны арилжаа зогсонги, эргэц сул байгааг илтгэж байна.

Хүснэгт-4

№	Огноо	Зах зээлийн үнэлгээ /сая ₮/	ДНБ /сая.төг/	ЗЗҮ/ДНБ /хувиар/	Хөрвөх чадвар	Хувьцааны арилжааны хэмжээ /сая .төг/
1	2010 он	1,373,946.2	9,756,588.4	14.1	0.046	62,873.1
2	2011 он	2,168,570.0	13,173,763.4	16.5	0.050	109,110.8
3	2012 он	1,799,898.9	16,688,419.6	10.8	0.080	144,746.5
4	2013 он	1,670,531.2	19,118,002.6	8.7	0.058	97,586.9
5	2014 он	1,442,655.0	21,844,250.3	6.6	0.017	24,241.8
6	2015 он	1,262,497.5	23,166,779.1	5.4	0.024	30,477.4

Хөрвөх чадварын түвшин бага байгаа нь голчлон хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хувьцаа эзэмшигч нарт төвлөрсөн, нийт бүртгэлтэй компаниудын дийлэнх нь 75 хувиас дээш төвлөрөлтэй, нэмж үнэт цаас гаргах сонирхол бага, гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт үйлчлэх кастодианы үйлчилгээ эхлээгүй, дэд бүтцийн байгууллагын уялдаа холбоо сул, арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг шинээр байгуулах Засгийн газрын шийдвэр гарсан боловч шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүй зэрэг нь нөлөөлжээ. Мөн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сул, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдан, худалдан авах үйлчилгээний төрөл хөгжөөгүй байгаа нь хөрвөх чадварын түвшин бага байхад давхар нөлөөлсөн.

Гэвч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,007-р өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд энэхүү өсөлтөнд ДНБ-ний хувь хэмжээ болон арилжааны хувь хэмжээ тус тус өссөн нь нөлөөлсөн.

Хүснэгт-5

№	Хугацаа	Зах зээлийн үнэлгээ /сая.төг/	Өөрчлөлт /сая.төг/ +/-	Өөрчлөлтийн хувь
1	2010 он	1,373,946.2	-111,448.7	-8.1
2	2011 он	2,168,570.0	-906,072.5	-41.8
3	2012 он	1,799,898.9	-537,401.4	-29.9
4	2013 он	1,670,531.2	-408,033.7	-24.4
5	2014 он	1,442,655.4	-180,157.9	-12.5
6	2015 он	1,262,497.5	-	-

Зах зээлийн үнэлгээг 2010 оны эцэстэй харьцуулахад 111.4 тэрбум төгрөгөөр буюу 8.1 хувиар, 2011 оны эцэстэй харьцуулахад 906.1 тэрбум төгрөгөөр буюу 41.8 хувиар, 2012 оны эцэстэй харьцуулахад 537.4 тэрбум төгрөг буюу 29.9 хувиар, 2013 оны эцэстэй харьцуулахад 408.0 тэрбум төгрөгөөр буюу 24.4 хувиар, 2014 оны эцэстэй харьцуулахад 180.2 тэрбум төгрөгөөр буюу 12.5 хувиар тус тус буурч, 1 их наяд 262.4 тэрбум төгрөг болсон байна. Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх онуудтай харьцуулахад дараах байдалтай байна.

График-6 /сая.төг/



Нийт зах зээлийн үнэлгээ сүүлийн 4 жил дараалан буурахад манай орны эдийн засгийн өсөлт буурсан, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом унасан, нийт эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалт буурсан болон үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол 2012 оноос хойш буурах хандлагатай болсон, зах зээлийн дэд бүтэц сул байгаа зэрэг нь нөлөөлж байна.

#### 1.4. Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани:

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-нд бүртгэлтэй, хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компанийг 2015 оны эцсийн байдлаар жагсаавал дараах байдалтай байх ба нийт зах зээлийн үнэлгээний 88.41 хувийг эзэлж байна. Үүнд:

Хүснэгт-6

№	Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ /тэрбум.төг/			
1	АПУ	289.42	16	ТАХЬ-КО	20.22
2	ТАВАН ТОЛГОЙ	155.36	17	ДАРХАН НЭХИЙ	20.17
3	ГОВЬ	66.15	18	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	19.51
4	УБ-БҮК	64.46	19	ТАЛХ ЧИХЭР	17.79
5	БАГАНУУР	51.81	20	АТАР-ӨРГӨӨ	11.32
6	ШИВЭЭ ОВОО	47.28	21	МАХИМПЕКС	10.79
7	ШАРЫН ГОЛ	39.18	22	СИЛИКАТ	10.43
8	БЭРХ УУЛ	36.22	23	GERMES ЦЕНТР	9.63
9	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	36.00	24	МАТЕРИАЛИМПЕКС	9.58
10	СҮҮ	33.71	25	АРИГ ГАЛ	8.18
11	БИ ДИ СЕК	32.96	26	МОНГОЛ ШИЛТГЭЭН	9.25
12	ГУТАЛ	28.33	27	ХӨХ ГАН	7.55
13	ХАЙ БИ ОЙЛ	21.89	28	ЖЕНКО ТУР БЮРО	7.50
14	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	20.70	29	УЛААНБААТАР ХИВС	6.11
15	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	20.31	30	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	5.67
			<b>Нийт</b>		<b>1,116.23</b>
			<b>Нийтэд эзлэх хувь</b>		<b>88.41</b>

### 1.5. Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаас:

Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан хувьцааны тоо ширхэгийн 99.02 хувь, нийт үнийн дүнгийн 92.44 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт-7

ҮНЭТ ЦААС	АРИЛЖИГДСАН ШИРХЭГ	Эрэмбэ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
ТАВАН ТОЛГОЙ	9,284,569	1	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	1,574,306,040
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	6,882,941	2	ТАВАН ТОЛГОЙ	1,540,167,671
ХӨХ ГАН	4,610,340	3	БИ ДИ СЕК	964,936,010
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	2,875,251	4	АПУ	952,920,336
РЕМИКОН	2,650,464	5	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	698,423,575
МЕРЕКС	1,919,507	6	ТАЛХ ЧИХЭР	524,922,580
ГЕРМЕС ЦЕНТР	1,636,131	7	ХӨХ ГАН	520,770,723
ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	1,318,569	8	МАТЕРИАЛИМПЕКС	368,238,870
БИ ДИ СЕК	546,970	9	ГОВЬ	362,709,570
ЖЕНКО ТУР БЮРО	339,628	10	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	270,306,645
АПУ	266,301	11	ГЕРМЕС ЦЕНТР	204,402,257
ТАЛХ ЧИХЭР	170,744	12	РЕМИКОН	196,458,625
ГОНИР	160,332	13	УБ-БУК	191,621,720
ОЛЛОО	155,819	14	СҮҮ	173,299,600
ХАЙ БИ ОЙЛ	105,968	15	МЕРЕКС	170,653,555
ӨНДӨРХААН	91,467	16	ДАРХАН НЭХИЙ	163,200,620
ЖИНСТ-УВС	90,476	17	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	133,676,150
МОНГОЛ САВХИ	72,112	18	МОНГОЛ КЕРАМИК	109,326,675
БАЯЛАГ НАЛАЙХ	64,388	19	ЕВРОФЁ АЗИА	97,394,900
БИНСЭ ХК	61,951	20	ГАЗАР СҮЛЖМЭЛ	91,239,890
МОНИНЖБАР	60,643	21	ШАРЫН ГОЛ	89,959,677
МОНГОЛ МАХ ЭКСПО	59,252	22	ГУТАЛ	86,724,140
БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ	54,611	23	МАХИМПЕКС	84,375,541
УУЖИМ ХАНГАЙ	46,529	24	ГАН ХЭРЛЭН	82,058,830
ГОВЬ	43,631	25	БАГАНУУР	78,635,668
БҮТЭЭЛЧ ҮЙЛС	39,212	26	АТАР-ӨРГӨӨ	74,055,000
ЕВРОФЁ АЗИА	30,415	27	МОНГОЛ САВХИ	72,286,974
БАГАНУУР	29,357	28	ДОРНОД АВТО ЗАМ	64,732,500
ХӨВСГӨЛ ХҮНС	28,732	29	МОГОЙН ГОЛ	61,561,420
МАХИМПЕКС	25,978	30	МОНГОЛ МАХ ЭКСПО	58,279,059
Нийт	<b>33,722,288</b>			<b>10,061,644,821</b>
Нийтэд хувьцааны тоо ширхэгт эзлэх хувь	<b>99.02</b>		Нийтэд хувьцааны арилжааны дүнд эзлэх хувь	<b>92.44</b>

### 1.6. Ханшийн өсөлттэй 20 үнэт цаас:

Тайлант хугацаанд 125 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39 компанийн үнэт цаасны ханш өсч, 69 компанийн үнэт цаасны ханш буурч, 17 компанийн үнэт цаасны ханш тогтмол байна.

Хүснэгт-8

№	Үнэт цаас	Хаалтын ханш 2014.12.31	2015.12.31	Ханшийн өөрчлөлт /төгрөг/	Өөрчлөлт хувнар
1	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	10.00	46.44	36.44	364.40
2	ТЕХНИК ИМПОРТ	695.00	1,605.00	910.00	130.94
3	ГУТАЛ	9,500.00	17,500.00	8,000.00	84.21
4	УЛААНСАН	1,000.00	1,592.00	592.00	59.20
5	ТАХЬ-КО	11,000.00	16,990.00	5,990.00	54.45
6	ТҮШИГ УУЛ	300.00	450.00	150.00	50.00
7	УУЖИМ ХАНГАЙ	155.00	225.93	70.93	45.76

8	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	227.27	315.00	87.73	38.60
9	МОНГОЛ НЭХМЭЛ	4,100.00	5,400.00	1,300.00	31.71
10	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	917.00	1,150.00	233.00	25.41
11	УЛААНБААТАР ХИВС	12,400.00	15,100.00	2,700.00	21.77
12	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	99.00	120.00	21.00	21.21
13	МОН НАБ	1,350.00	1,612.00	262.00	19.41
14	МОН-ИТ БУЛИГААР	8,000.00	9,500.00	1,500.00	18.75
15	ЖУУЛЧИН ГОВЬ	3,600.00	4,250.00	650.00	18.06
16	ХЭСӨГ ТРЕЙД	1,200.00	1,400.00	200.00	16.67
17	МОНГОЛ ШИЛТГЭЭН	690.00	800.00	110.00	15.94
18	ХӨВСГӨЛ ХҮНС	591.15	680.00	88.85	15.03
19	ХАРХОРИН	1,400.00	1,610.00	210.00	15.00
20	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	21.16	24.33	3.17	14.98


### 1.7. Ханшийн бууралттай 20 үнэт цаас:

Хүснэгт-9

№	Үнэт цаас	Хаалтын ханш 2014.12.31	2015.12.31	Ханшийн өөрчлөлт /төгрөг/	Өөрчлөлт хувиар
1	УВС ЧАЦАРГАНА	2,550.00	950.00	-1,600.00	-62.75
2	МОНГОЛ МАХ ЭКСПО	3,780.00	1,550.00	-2,230.00	-58.99
3	ИХ БАРИЛГА	11,000.00	5,000.00	-6,000.00	-54.55
4	АГРОТЕХИМПЕКС	2,950.00	1,380.00	-7,995.00	-53.22
5	МАТЕРИАЛИМПЕКС	14,900.00	7,005.00	-1,570.00	-52.99
6	МОННООС	4,700.00	2,430.00	-48.96	-48.30
7	БЭРХ УУЛ	3,579.00	1,900.00	-2,270.00	-46.91
8	РЕМИКОН	99.00	54.00	-1,679.00	-45.45
9	АВТО ИМПЕКС	4,000.00	2,332.00	-1,668.00	-41.70
10	МОГОЙН ГОЛ	9,900.00	5,865.00	-4,035.00	-40.76
11	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	1,300.00	800.00	-500.00	-38.46
12	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	784.50	490.00	-294.50	-37.54
13	БАЯЛАГ НАЛАЙХ	689.00	440.00	-249.00	-36.14
14	МОНИНЖБАР	210.00	135.00	-75.00	-35.71
15	БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ	2,470.00	1,600.00	-870.00	-35.22
16	ШАРЫН ГОЛ	5,900.00	3,852.00	-2,050.00	-34.71
17	ТАВАН ТОЛГОЙ	4,400.00	2,950.00	-197.14	-32.95
18	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	800.00	550.00	-1,357.00	-31.25
19	ШИВЭЭ ОВОО	4,999.00	3,523.00	-250.00	-29.53
20	НАКО ТҮЛШ	280.00	200.00	-680.00	-28.57

### 1.8.Топ-20 индекс:

График-7






Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15,737.17 нэгж, доод үзүүлэлт 12,477.28 нэгж, дундаж үзүүлэлт 11,962.11 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,956.65 нэгжээр буюу 13.17 хувиар буурч, 12,897.59 нэгж болсон байна.

### 1.9. MSE ALL индекс:

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 1057.89, доод үзүүлэлт нь 854.84, дундаж үзүүлэлт 953.29 нэгж байв.

График-8



### 1.10. Засгийн газрын үнэт цаасны арилжаа:

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртлэх хугацаанд нийт 510.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.4 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжигдаад байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-10

№	Хугацаа	Зарласан тоо хэмжээ	Биелсэн тоо хэмжээ	Биелсэн Дүн /төгрөг/	Жигнэсэн дундаж хүү	Эзлэх хувь	Биелсэн хувь хэмжээ	Арилжаа зохион байгуулсан удаа
1	12 долоо хоног	7,544,453	3,410,510	329,857,850,669	14.7%	63.3%	61.8%	21
2	28 долоо хоног	4,607,375	1,072,692	99,628,732,314	14.3%	19.9%	46.6%	15
3	52 долоо хоног	3,226,568	900,997	80,483,798,456	14.9%	16.7%	51.0%	16
4	156 долоо хоног	699,342	3,686	368,600,000	15.9%	0.1%	3.6%	7
5	260 долоо хоног	199,596	20	2,000,000	16.8%	0.0%	0.0%	2
Нийт		<b>16,277,334</b>	<b>5,387,905</b>	<b>510,340,981,439</b>	-	<b>100.0%</b>	-	<b>61</b>

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар арилжаалагдсан ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

График-9





График-10



ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 52.3 мянган ширхэг үнэт цаас 5.1 тэрбум төгрөгөөр арилжигдсан байна. Хоёрдогч зах зээлийн арилжаа эрчимтэй хөгжихгүй байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд: Үнэт цаасны зах зээлийн багтаамж бага, иргэдийн тус зах зээлд итгэх итгэл сул, илүүдэл мөнгөн хөрөнгөө банкны хадгаламжид байршуулах сонирхол өндөр, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид байхгүйгээс шалтгаалан санхүүжүүлэхээр зорьж буй хөрөнгийг бүрэн татан төвлөрүүлэх боломж хомс байна.

Монголбанкаар арилжаалсан ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-11

№	Хугацаа	Зарласан тоо ширхэг	Биелсэн тоо ширхэг	Нэрлэсэн үнэ	Нийт дүн /төгрөг/	Эзлэх хувь	Биелсэн хувь хэмжээ
1	12 долоо хоног	935,000	877,000	1,000,000	877,000,000,000	46.3%	93.8%
2	28 долоо хоног	270,000	193,500	1,000,000	193,500,000,000	10.2%	71.7%
3	52 долоо хоног	305,000	391,415	1,000,000	391,415,000,000	20.7%	128.3%
4	78 долоо хоног	600,000	298,100	1,000,000	298,100,000,000	15.7%	49.7%
5	156 долоо хоног	250,000	135,000	1,000,000	135,000,000,000	7.1%	54.0%
6	260 долоо хоног	85,000	-	1,000,000	-	0.0%	0.0%
<b>Нийт</b>			<b>1,895,015</b>		<b>1,895,015,000,000</b>	<b>100.0%</b>	

Статистик мэдээллээс харахад 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа хамгийн их буюу 46.3 хувь /877.0 тэрбум төгрөг/-ийг эзэлж байна. Монголбанкаар 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 12, 28, 52, 156 долоо хоногийн хугацаатай, нийт 11,895.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсан байна.

Монголбанкар арилжаалсан ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

График-11



Монголбанк болон Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан ЗГҮЦ-ны арилжааны үнийн дүнг харьцуулан доорхи хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт-12

ЗГҮЦ-ны арилжаа явуулсан	Үнийн дүн /сая.төг/	Хувь
<b>Монголбанк</b>	1,895,015.0	78.6%
<b>"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК</b> /Анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа/	515,463.7	21.4%
<b>Нийт</b>	<b>2,410,478.7</b>	<b>100.0%</b>

Жич: Монголбанкны ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 1 сая төгрөг, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 100 мян.төгрөг болно.

### 1.11. Компанийн бондын арилжаа:

Тайлан хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь “Эрчим инженеринг” ХХК-иас олон нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50.0 мянган ширхэг “Эрчим” бондыг 500.0 сая төгрөгөөр арилжаалсан байна.

## 2. ҮНЭТ ЦААСНЫ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭ

### 2.1. “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТТТХТ/” ХХК-иар хийгдсэн гүйлгээ:

“ҮЦТТТХТ” ХХК-иар 2015 онд нийт 6.3 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдсэн ба энэ нь 2014 оныхоос 3.1 их наяд төгрөгөөр буюу 2.0 дахин, 2013 оныхоос 3.2 их наяд төгрөгөөр буюу 2.0 дахин, 2012 оныхоос 5.5 их наяд төгрөгөөр буюу 7.6 дахин, 2011 оныхоос 5.9 их наяд төгрөгөөр буюу 17.0 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-13 /тэрбум.төг/

№	Гүйлгээний төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	Хувьцаа	347.6	517.6	93.8	107.3	842.2
2	ЗГБ	19.4	293.2	3,016.6	3,061.7	5,129.1
3	Бусад	6.5	20.3	8.9	58.9	379.1
	<b>Нийт</b>	<b>373.5</b>	<b>831.1</b>	<b>3,119.3</b>	<b>3,227.9</b>	<b>6,350.4</b>

График-12/тэрбум.төг/



График-13



Тайлант хугацаанд төвлөрсөн хадгаламжийн дансаар нийт 918 харилцагчийн дансанд 3,553 удаа 3,175,219.9 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 2,961 харилцагчийн 4,645 удаа 3,175,629.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээ, нийт 3,879 харилцагчийн дансанд 8,198 удаагийн 6,350,848.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдсэн байна. Үүнд:

- ҮЦТТТХТ банкаар нийт 2 421 удаагийн 3,171,119.1 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдэж үүнээс их дүнтэй 1 344 удаагийн 3,170,832.6 сая төгрөг, харин бага дүнтэй 1 077 удаагаар 286.5 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн байна.
- ҮЦТТТХТ банкаар нийт 4 577 удаагийн 3,175,099.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн. Үүнээс их дүнтэй 1 493 удаагаар 3,174,602.8 сая төгрөгийн гүйлгээ, харин бага дүнтэй 3 084 удаагийн 496.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.
- Төрийн банкаар нийт 1 132 удаагийн 4,100.8 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдэж үүнээс их дүнтэй 103 удаагаар 4,049.0 сая төгрөг, харин бага дүнтэй 1 029 удаагаар 51.8 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн байна.
- Төрийн банкаар нийт 68 удаагийн 529.4 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэний 26 удаагийн 525.7 сая төгрөг нь их дүнтэй, харин 42 удаагийн 3.7 сая төгрөг нь бага дүнтэй гүйлгээ хийгдсэн.

## 2.2. Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ

Он	Орлогын гүйлгээ		Зарлагын гүйлгээ	
	Гүйлгээний тоо	Үнийн дүн	Гүйлгээний тоо	Үнийн дүн
2011 онд	8 752	406,986.5	12 663	404,015.6
2012 онд	6 590	269,516.9	9 823	248,884.1
2013 онд	1 914	1,550,055.2	4 383	1,569,249.9
2014 онд	2 171	1,611,995.3	3 476	1,615,914.5
2015 онд	3 553	3,175,219.9	4 645	3,175,629.0

Мөнгөн хөрөнгийн гүйлгээний нийт дүнг өмнөх онуудтай харьцуулахад 2015 оны нийт орлого зарлагын гүйлгээний дүн 2014 оноос 1,9 дахин их, 2013 оноос 2 дахин их үзүүлэлттэй байна. Харин төлбөр тооцооны орлого, зарлагын гүйлгээний тоо 2015 онд 8 198 байгаа нь 2014 оноос 1,4 дахин их, 2013 оноос 1,3 дахин өссөн байна.

График-14 /сая төгрөгөөр/





График-15/сая төгрөгөөр/



### 2.3. Төлбөр гүйцэтгэх банкаар хийгдсэн арилжааны төлбөр:

2015 онд төлбөр гүйцэтгэх 4 банкаар нийт 7,195.7 сая төгрөгийн арилжааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Голомт банк-2,506.9 сая төгрөг, ХХБ-1,432.5 сая төгрөг, Хас банк-3,019.0 сая төгрөг, ХААН банк-237.3 сая төгрөгийн гүйлгээг тус тус хийгдсэн.

**2.4. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо**

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ээр 2015 онд нийт 252 удаагийн арилжаа явагдаж 11,462 хэлцлээр нийт 546,4 тэрбум төгрөгийн 41,3 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан. Үүнээс “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “ҮЦТТТХТ” ХХК, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллага нийт 1.1 тэрбумтөгрөгийн арилжааны шимтгэлийг тооцон авсан байна. Үнэт цаасны арилжааны дүн болон шимтгэлийн дүнг өмнөх онуудын үзүүлэлттэй харьцуулан дараах хүснэгтээр харуулав:

Үзүүлэлт	Хүснэгт-15/сая төгрөгөөр/				
	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Арилжааны үнийн дүн	350,235.9	145,056.7	98,609.2	60,358.5	546,401.7
Шимтгэлийн дүн	534.7	693.9	452.4	117.6	1,146.3
Шимтгэлийн орлогын өсөлт+ /бууралт/-		+159.2	-241.5	-345.9	1,028.7

2015 оны арилжааны шимтгэлийн дүн 2013 оноос 2.5 дахин их, 2014 оноос 9.7 дахин их байна. Энэ нь 2015 онд Засгийн газрын үнэт цаасны 515.4 тэрбум төгрөгийн арилжааг хөрөнгийн биржээр дамжуулан хийсэнтэй холбоотой юм.

**2.5. Хадгаламж өмчлөх эрх бүртгэлийн үйл ажиллагаа**

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд 2015 онд 321 ХК-ийн 20,258,045,096 ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас төрийн өмчтэй 37 ХК-ийн 14,683,001,261 хувьцаа, орон нутгийн өмчтэй 9 ХК-ийн 29,045,916 ширхэг хувьцаа байна. Төрийн өмчийн 37 ХК-иас Эрдэнэст таван толгой ХК нь хаалттай бүртгэлтэй байна.

Төвлөрсөн хадгаламжинд нийт 25 төрлийн 20,951,245 ширхэг компанийн бонд, 114 төрлийн 4,728,503 ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс 20 төрлийн 20,668,281 ширхэг Компанийн бонд, 51 төрлийн 2,414,613 ширхэг Засгийн газрын бонд нь биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 онд баталсан “Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу бүртгүүлэх хүсэлт, баримт ирүүлсэн 2 хаалттай ХК-ийн /Хөдөө аж ахуйн давхар даатгал ХХК, Ард санхүүгийн нэгдэл ХХК/ 172,752,700 ширхэг хувьцааг төвлөрсөн хадгаламжид бүртгэн хадгалж байна.

Хүснэгт-16

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
<b>1. Бүртгэлтэй үнэт цаас</b>					
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,555,045	2,665,629	2,595,868	2,913,776	2,809,930
Төрийн мэдлийн хувьцаа	356,933	1,979,932	1,951,589	2,254,152	2,246,316
Орон нутгийн оролцоотой	29,128	29,046	29,046	29,046	29,046
<b>Нийт хувьцаа</b>	<b>2,941,106</b>	<b>4,674,607</b>	<b>4,576,503</b>	<b>5,196,974</b>	<b>5,085,292</b>
Засгийн газрын бонд	4,238	4,335	2,348	2,510	2,415
Компанийн бонд	3,233	694	233	233	283
<b>Нийт бондын тоо</b>	<b>7,471</b>	<b>5,029</b>	<b>2,581</b>	<b>2,743</b>	<b>2,698</b>
<b>2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас</b>					
Компанийн бонд	22	21	3,300	8,402	20,668
Засгийн газрын бонд	1,000	1,293	2,531	2,512	2,314
<b>Нийт бондын тоо</b>	<b>1,022</b>	<b>1,314</b>	<b>5,831</b>	<b>10,914</b>	<b>22,982</b>
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	-	1,463,519	1,463,519	967,134	2,558,176
Эрдэнэс Тавантолгой /ААН/	-	16,692	5,046	4,915	5,139
Эрдэнэс Тавантолгой /Төр/	15,000	13,519,789	13,531,435	14,027,951	12,436,685

Нийт	15,000	15,000,000	15,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай хувьцаат компани	-	-	-	-	172,753
<b>Нийт</b>	-	-	-	-	<b>172,753</b>

2015 оны жилийн эцсийн байдлаар “ҮЦТТТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид төрийн мэдлийн нийт 37 ХК-ийн 14,6 тэрбум ширхэг хувьцаанаас МХБ-д бүртгэлтэй 35 ХК-ийн 2,246,316,081 ширхэг хувьцаа, биржийн бус зах зээлд бүртгэлтэй 1 ХК-ийн /Эрдэнэс тавантолгой ХК/ 12,436,685,180 ширхэг хувьцаа байна.

## 2.6. Ногдол ашгийн гэрээ, ногдол ашиг тараалт

“ҮЦТТТХТ” ХХК нь 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 18 ХК-тай ногдол ашгийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 15,734,000 төгрөг тооцож, нийт 30,367 харилцагчийн дансанд 403.9 сая төгрөгийн ногдол ашгийг байршуулсан.

Компаниар тарагдсан ногдол ашгийн жагсаалт

Хүснэгт-17 /төгрөг/

Он	ХК-ийн тоо	ХЭ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан мөнгөн дүн
2010	1	728	43,505	10,908,008.65
2011	1	4,132	195,457	1,954,570.00
2012	5	125,441	21,448,896	178,479,491.79
2013	23	117,214	328,361,217	1,101,581,551.73
2014	15	32,237	33,205,774	947,280,678.91
2015	18	30,367	28,010,137	403,990,442.00

## 2.7. Ногдол хувийн гэрээ, ногдол хувь тараалт

“ҮЦТТТХТ” ХХК нь 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 5 ХК-тай ногдол хувийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 2,842,500 төгрөг тооцож, нийт 5,385 харилцагчийн дансанд 1,055 сая төгрөгийн ногдол ашгийг байршуулсан байна.

Мөн 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдөр гэрээ байгуулж үйлчилгээний хөлсөө төлсөн боловч гэрээнд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол хувийн дутуу мөнгийг шилжүүлж дууссан тул “Хялганат” ХК-ийн 428 хувьцаа эзэмшигчийн 1,304 ширхэг хувьцаанд ногдох 30,407,428.32 төгрөгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт-18

№	ХК-ийн нэр	Бүртгэх өдөр	Нэгж үнэ	ХЭ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан мөнгө	Дансанд байршуулсан огноо
1	"Хялганат" ХК	10/8/2014	23,319	428	1,304	30,407,428	2/3/2015
2	"Дорнод Хүнс" ХК	5/20/2015	760	1,274	163,019	123,894,440	5/28/2015
3	"Монголын Гэгээ" ХК	6/24/2015	3,457	692	36,628	126,622,996	7/3/2015
4	"Бишрэлт Индастриал" ХК	7/3/2015	992	2,655	104,126	103,292,992	8/28/2015
5	"Азиапасифик пропертис" ХК	7/10/2015	2,460	466	244,140	600,584,400	7/3/2015
6	"Монгол Мах Экспо" ХК	7/3/2015	1,955	298	51,914	101,491,870	7/17/2015
7	"Зоос Гоёл" ХК	9/25/2015	850	11,395	1,072,825	911,901,250	12/31/2015
Нийт дүн				<b>17,208</b>	<b>1,673,956</b>	<b>1,998,195,376</b>	

## 2.8. Үнэт цаасны өмчлөх эрх, бүртгэл

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлсэнээс хойш “ҮЦТТТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжинд өссөн дүнгээр нийт 804,964 данс, 135,276 холболтын данс нээгдсэн.

Нийт нээгдсэн данснаас 800,478 нь дотоодын иргэн, 1,831 гадаадын иргэн, 2,479 дотоодын аж ахуйн нэгж, 176 гадаад аж ахуйн нэгжийн данс нээгдсэн.

Тайлант хугацаанд нийт 19,101 данс нээгдсэний 18,985 нь дотоодын иргэдийн, 67 нь гадаадын иргэдийн данс, аж ахуйн нэгжийн хувьд дотоодын 46, гадаадын аж ахуйн нэгжийн 3 данс нээгдсэн байна. Дээрх тоог хувилж үзвэл нийт нээгдсэн дансны 99%-ийг дотоодын иргэн, ААН, үлдэх 1 хувийг гадаадын иргэн, ААН-ийн данс эзэлж байна.

## 2.9. Өмчлөх эрх шилжүүлэх

“ҮЦТТТХТ” ХХК нь 2015 онд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх гүйлгээг дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Өв залгамжлалаар нийт 520 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 107 ХК-ийн 220,195 ширхэг хувьцаа, 70 сая төгрөгийн өмчлөх эрхийг шилжүүлж нийт 5,317,999.97 төгрөгийн шимтгэл тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 4,254,399.98 төгрөгийн шимтгэлийг тооцсон. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 1,063,599.99 төгрөгний шимтгэл тооцсон байна.

- Бэлэглэлээр 30 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 15 ХК-ийн 602,084 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлж, нийт 5,730,073.10 төгрөгийн шимтгэл тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 4,584,058.48 төгрөгийн шимтгэлийг, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 1,146,014.62 төгрөг тооцсон байна.

- Шүүхийн шийдвэрээр 2 харилцагчийн 2 ХК-ийн 10,579 ширхэг хувьцаа шилжүүлж 128,706.89 төгрөг тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 102,965.49 төгрөгийн шимтгэлийг, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 25,741.37 төгрөг тооцсон.

- Төрийн мэдлийн хувьцааг худалдан авагчид шилжүүлэх 1 удаагийн гүйлгээгээр “Хөтлийн цемент шохой” ХК-ийн 73,563,158 ширхэг хувьцааг шилжүүлж, шимтгэлд 853,612.96 төгрөг тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 768,251.96 төгрөгийн шимтгэлийг, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 85,361.30 төгрөг тооцсон.

- БДК-ийн хүсэлтээр 1 харилцагчийн 1 ХК-ийн 174 ширхэг хувьцаа шилжүүлж 5,819.69 төгрөг тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 5,237.73 төгрөгийн шимтгэлийг, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 581.97 төгрөг тооцсон.

- Нэмж гаргасан үнэт цаасыг нэр заан эзэмшүүлэх 7 удаагийн гүйлгээгээр 206,8 сая ширхэг хувьцаа шилжүүлж, 51,760,204.45 төгрөгийг шимтгэл тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 43,795,174.30 төгрөгийн шимтгэлийг, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 7,965,030.15 төгрөг тооцсон байна.

### Шигтгээ-2:

- *Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханин унасантай холбоотойгоор уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, эдийн засгийн огцом өсөлт саарсан нь эргээд хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны үнийг бууруулсан;*
- *Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын өмчлөх эрхийг баталгаажуулах кастодианы үйлчилгээ зах зээлд нэвтэрсэн боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл дутмаг;*
- *Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг арилжаанд оролцоход дэмжлэг үзүүлэх татварын таатай орчин бүрдээгүй;*
- *Зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо сул, мэргэжлийн оролцогч байгууллагуудын гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг зах зээлд татах чадавхи сул.*



**3. БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН БҮРТГЭЛ:****3.1. Бүртгэлтэй хувьцаат компаниуд:**

Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон “ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт -19

Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-нд бүртгэлтэй	“ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй
100% Төрийн өмчийн	32	21	22
Төрийн өмчийн оролцоотой	10	16	15
Орон нутгийн оролцоотой	15	-	9
Хувийн өмчийн	243	198	273
<b>Нийт</b>	<b>300</b>	<b>235</b>	<b>319</b>

Хороонд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 300 компани бүртгэлтэйгээс 100 хувь төрийн өмчийн 32, төрийн өмчийн оролцоотой 10, орон нутгийн оролцоотой 15, хувийн өмчит 243 /үүнээс 90 хувьцаат компанийн арилжааг зогсоосон/ компани, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн бүртгэлд нийт 236 хувьцаат компани бүртгэлтэйгээс 100 хувь төрийн өмчийн 21, төрийн өмчийн оролцоотой 15, хувийн өмчит 200 компани бүртгэлтэй байгаа бол “ҮЦТТТХТ” ХХК-ийн бүртгэлд нийт 322 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас 100 хувь төрийн өмчийн 19, төрийн өмчийн оролцоотой 11, орон нутгийн оролцоотой 15, хувийн өмчит 277 компани бүртгэлтэй байна.

**3.2. Бүртгэлтэй компаниудын ногдол ашиг тараалтын байдал:**

Тайлант хугацаанд нэр бүхий 23 хувьцаат компани нийт 199,854,730 ширхэг хувьцаанд ногдох нийт 7,313,698,806.5 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Хүснэгт-20

Д/д	Компанийн нэрс	Нэгж хувьцаанд тараах ногдол ашгийн мөнгөн дүн	Нийт хувьцааны тоо ширхэг	Ногдол ашгийн нийт дүн /төгрөг/	Бүртгэх өдөр	Тараах хэлбэр
1	Тахь Ко	82	1 189 983.0	97 578 606.0	2015.03.16	ҮЦТТТХТ
2	Говь	140	7 801 125.0	1 092 157 500.0	2015.02.27	ХК, ҮЦТТТХТ
3	Монинжбар	5	15 869 233.0	79 346 165.0	2015.03.03	ХК
4	Гермес центр	4.07	78 543 001.0	319 670 014.1	2015.02.28	ХК, ҮЦТТТХТ
5	Бинсэ	10	1 268 320.0	12 683 200.0	2015.02.26	-
6	УБ БҮК	66	1 128 275.0	74 466 150.0	Ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр	ХК
7	Ариг гал	42.51	3 479 320.0	147 905 893.2	-	-
8	Эрдэнэт суврага	5	156 054.0	780 270.0	2015.03.02	ҮЦТТТХТ
9	Баянтээг	100	252 608.0	25 260 800.0	2015.03.14	ҮЦТТТХТ
10	Махимпекс	100	3 800 721.0	380 072 100.0	2015.03.26	ХК
11	Талх чихэр	120	1 023 703.0	122 844 360.0	2015.03.31	ХК
12	Газар сүлжмэл	13196.8	65 362.0	862 569 241.6	2015.02.20	ХК
13	Монголын цахилгаан холбоо	6.0637	25 870 276.0	156 869 592.6	2015.04.02	ҮЦТТТХТ
14	Ган хэрлэн	300	99 899.0	29 969 700.0	-	-
15	Таван толгой	59	52 665 200.0	3 107 246 800.0	2015.03.09	ҮЦТТТХТ, ХК
16	Тавилга	408	122 754.0	50 083 632.0	2015.04.02	ҮЦТТТХТ, ХК

**СЗХ | Үнэт цаасны зах зээлийн тойм /2015 оны 2 дугаар улирал/**

17	Адуунчулуун	85	3 151 304.0	267 860 840.0	2015.03.27	ҮЦТТТХТ, ХК
18	Ган хийц	100	242 464.0		2015.03.05	ҮЦТТТХТ, ХК
19	Хөвсгөл алтан дуулга	221.89	113 286.0		2015.03.23	-
20	Ачит алкабы	30	74 127.0	2 223 810.0	2015.03.10	-
21	Техник импорт	300	1 446 755.0	434 026 500.0	2015.03.16	ХК
22	Материал импекс	80	1 368 206.0		2015.02.24	ҮЦТТТХТ
23	Тавилга	408	122 754.0	50 083 632.0	-	-
<b>НИЙТ</b>			<b>199 854 730.0</b>	<b>7 313 698 806.5</b>		

Тайлант хугацаанд “Бишрэлт индастриэл” ХК, “Дорнод хүнс” ХК, “Монголын гэгээ” ХК, “Азиа пасифик пропертис” ХК-иуд буюу нийт 4 хувьцаат компани нь Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох хууль, журмын дагуу хүсэлт гаргаж, нийтэд гаргасан хувьцаагаа үнэт цаасны бүртгэлээс хасуулсан.

Харин 2015 оны 3 дугаар улирлын байдлаар “ҮЦТТТХТ” ХХК нь 1 хувьцаат компанитай ногдол хувийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 667,000 төгрөг тооцож, нийт 1,274 харилцагчийн дансанд 123.9 сая төгрөгийн ногдол хувийн мөнгийг байршуулсан байна.

2014 оны 12 дугаар сарын 08-ны өдөр гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөө төлсөн боловч гэрээнд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол хувийн дутуу мөнгийг шилжүүлж дууссан тул “Хялганат” ХК-ийн 428 хувьцаа эзэмшигчийн 1,304 ширхэг хувьцаанд ногдох 30,407,428.32 төгрөгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан.

Тайлант хугацаанд “ҮЦТТТХТ” ХХК-тай ногдол хувь тараах гэрээ байгуулан ногдол хувь тараасан хувьцаат компаниудын талаарх мэдээллийг харуулахад:

Хүснэгт-21

№	Код	ХК-ийн нэр	Бүртгэх өдөр	Нэгж үнэ	ХЭ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан мөнгө	Дансанд байршуулсан огноо
1	114	"Хялганат" ХК	10/8/2014	23,319	428	1,304	30,407,428	2/3/2015
2	343	"Дорнод Хүнс" ХК	5/20/2015	760	1,274	163,019	123,894,440	5/28/2015
3	362	"Монголын Гэгээ" ХК	6/24/2015	3,457	692	36,628	126,622,996	7/3/2015
4	264	"Бишрэлт Индастриал" ХК	7/3/2015	2,509	2,655	104,126	261,252,134	8/28/2015
5	384	"Азиапасифик пропертис" ХК	7/10/2015	2,460	466	244,140	600,584,400	7/3/2015
6	226	"Монгол Мах Экспо" ХК	7/3/2015	1,955	298	51,914	101,491,870	7/17/2015
<b>Нийт дүн</b>					<b>5,813</b>	<b>601,131</b>	<b>1,244,253,268</b>	

**3.3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан өөрчлөлт:**

Хүснэгт-22

Үзүүлэлт	2014 он		2015 он		Өөрчлөлт	
	Компанийн тоо	Үнэт цаасны үнэлгээ	Компанийн тоо	Үнэт цаасны үнэлгээ	Компанийн тоо	Үнэт цаасны үнэлгээ
Олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгон гаргасан компанийн хувьцааны бүртгэл	0	0	2	266,935,317,155₮	2	-
Хувийн хэвшлийн компанийн нэмж гаргасан хувьцааны бүртгэл	2	11,691,261,400₮	4	15,576,937,116₮	2	33.24%
Төрийн өмчит компанийн нэмж гаргасан хувьцааны бүртгэл	5	25,047,643,700₮	6	292,118,409,700₮	1	1066.25 %
Үнэт цаасны бүртгэлээс хасагдсан хувьцааны бүртгэл	21	38,777,951,889₮	5	11,198,305,290₮	-16	-71.12%
ХБҮЦ-ны бүртгэл	2	553,384,800,000 ₮	3	1,028,395,200,000₮	1	85.84%
Гадаадын зах зээлд гаргах бондын бүртгэл	2	1,000,000,000\$	3	1,000,000,000\$	1	-
		1,500,000,000€		500,000,000€		-
Дотоодын зах зээлд гаргасан бондын бүртгэл	0	0	1	500,000,000₮	1	-

**СЗХ | Үнэт цаасны зах зээлийн тойм /2015 оны 2 дугаар улирал/**

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэл	0	0	1	58,000,000,000₮	1	-
--	---	---	---	-----------------	---	---

**4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭТГЭЭД:****4.1. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах этгээдийн тоо:**

2015 оны эцсийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны компани /ҮЦК/ 61, үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банк 3, хөрөнгө оруулалтын менежментийн 7, бараа, түүхий эдийн арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 37 нийт 112 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-23

№	Тусгай зөвшөөрлийн төрлөөр	Зуучлалттай этгээдийн тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн	1
3	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	7
5	Брокер, дилерийн	61
6	Кастодианы үйлчилгээ үзүүлэх	3
7	Давхардсан тоогоор андеррайтерийн	22
8	Давхардсан тоогоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн	16
	<b>НИЙТ</b>	<b>74</b>
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн Брокер	37
	<b>БҮГД</b>	<b>112</b>

Хорооны 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 312 дугаар тогтоолоор “Дилерийн арилжааны төв” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Монгол улсын хувьд 2 дахь бирж байгуулагдсан энэхүү үйл явдал нь зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож, үйлчилгээний зардлыг бууруулах, ингэснээр зах зээлд оролцогчдод эерэгээр нөлөөлөх давуу талтай.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 54.1-д “Зохицуулалттай этгээд нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитийн шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг аудитийн дүгнэлтийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн заавар, маягтын дагуу ҮЦК-иуд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлан гаргаж, 52 ҮЦК мастер файлын дагуу шивж, Хорооны ФИНА систем рүү илгээсэн бөгөөд мөн цаасан хэлбэрээр баталгаажуулан ирүүлсэн.

Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 74 зохицуулалттай этгээд байгаагаас арилжаа эрхлэх болон төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх 3, кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх 7, нийт 13 компанийн санхүүгийн тайланг нэгтгэлд оруулаагүй болно. Мөн санхүүгийн тайлангаа ирүүлээгүй нэр бүхий 9 ҮЦК-иудыг нэгтгэлийн үзүүлэлтэд оруулаагүй болно.

ФИНА системийн дагуу мастер файлаар шивж, цаасаар баталгаажуулан ирүүлсэн нийт 52 ҮЦК-ийн санхүүгийн байдлын болон орлогын дэлгэрэнгүй тайланг, хавсралт-2.3, хавсралт 2.4-т тусгасан болно.

## 4.2. ҮЦК-иудын ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүд:

ҮЦК-иудын ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүдийг тооцохдоо санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлсэн 52 ҮЦК-ийн хувьд тооцсон болно.

Хүснэгт-24 /мянган төгрөг/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015-12-31
1	Тайлан ирүүлсэн	52 ҮЦК
2	Эргэлтийн хөрөнгийн дүн	47,543,265,612.05
3	Эргэлтийн бус хөрөнгө	20,410,824,681.02
4	<b>Нийт актив</b>	<b>67,954,090,293.07</b>
5	Өр төлбөр	6,369,641,323.57
6	Эздийн өмч	61,584,448,969.50
7	<b>Нийт пассив</b>	<b>67,954,090,293.07</b>

## 4.3. ҮЦК-иудын Активын бүтэц:


Нэгтгэлд хамрагдсан нийт 52 ҮЦК-иудын активын бүтэц 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-25 /мянган төгрөг/

Актив	Тайлант үе	Хувь
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>47,543,265,612.05</b>	<b>70.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,151,794,016.65	7.6
Касс дахь мөнгө	1,597,995,534.45	2.4
Банкин дахь мөнгө	3,516,980,168.63	5.2
Дансны авлага (цэврээр)	4,951,404,857.14	7.3
Татвар, НДШ-ийн авлага	12,376,652.94	0.0
Бусад авлага	1,147,657,460.64	1.7
Санхүүгийн хөрөнгө	34,753,498,782.74	51.1
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	935,761,752.41	1.4
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>20,410,824,681.03</b>	<b>30.0</b>
Үндсэн хөрөнгө (цэврээр)	7,475,873,037.74	11.0
Биет бус хөрөнгө (цэврээр)	209,066,430.47	0.3
Биет бус хөрөнгө	264,452,378.39	0.4
<b>Хөрөнгө</b>	<b>67,954,090,293.08</b>	<b>100.0</b>

Нэгтгэлд хамрагдсан ҮЦК-иудын нийт актив тайлант үеийн байдлаар 67.95 тэрбумтөгрөг байх ба нийт активын 70.0 хувийг эргэлтийн хөрөнгө, 30.0 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна. Үүнийг задалж үзвэл мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт активын 7.6 хувийг, авлага 7.3 хувийг, бусад авлага 1.7 хувийг, урьдчилж төлсөн зардал/тооцоо 1.4 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө урьдчилж төлсөн тооцоо зардал 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн хувьд үндсэн хөрөнгө /цэврээр/ нийт активын 11.0 хувийг, биет бус хөрөнгө /цэврээр/ 0.4 хувийг тус тус эзэлж байна.



#### 4.4. ҮЦК-иудын Пассивын бүтэц:

Нэгтгэлд хамрагдсан нийт 52 ҮЦК-иудын пассивын бүтэц 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна Үүнд:

Хүснэгт-26 /төгрөгөөр/

Пассив	Тайлант үе	Хувь
<b>Өр төлбөр</b>	<b>6,369,641,323.57</b>	<b>9.37</b>
Богино хугацаат өр төлбөр	5,059,309,008.05	7.45
Дансны өглөг	2,702,903,116.26	3.98
Татварын өр	153,151,898.95	0.23
Богино хугацаат зээл	547,330,970.87	0.81
Урт хугацаат өр төлбөр	1,310,332,315.52	1.93
Урт хугацаат зээл	1,097,772,897.39	1.62
<b>Эздийн өмч</b>	<b>61,584,448,969.50</b>	<b>90.63</b>
Өмч	47,505,727,579.68	69.91
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,019,909,518.98	5.92
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-37,526,480.00	(0.06)
Хуримтлагдсан ашиг, алдагдал	-90,835,799.45	(0.13)
Тайлангийн үе	-750,924,424.75	(1.11)
Өмнөх үеийн	660,088,625.30	0.97
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>67,954,090,293.07</b>	<b>100.00</b>


Нийт пассив тайлант үеийн байдлаар 67.9 тэрбумтөгрөг байх бөгөөд нийт пассивын 9.37 хувийг өр төлбөр, эздийн өмч 90.63 хувийг тус тус эзэлж байна. Үүнийг дотор бүтэцээр нь авч үзвэл богино хугацаат өр төлбөр нийт пассивын 7.45 хувийг, дансны өглөг нийт активын 3.98 хувийг, татварын өр 0.23 хувийг, богино хугацаат зээл 0.81 хувийг, урт хугацаат өр төлбөр 1.93 хувийг, урт хугацаат зээл 1.62 хувийг тус тус эзэлж байна.

### СЗХ | Үнэт цаасны зах зээлийн тойм /2015 оны 2 дугаар улирал/

Эздийн өмчийн хувьд өмч нийт активын 69.91 хувийг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 5.92 хувийг, Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц -0.06 хувийг, хуримтлагдсан алдагдал -0.13 хувийг тус тус эзэлж байна.

#### Салбарын тайлант улирлын нийт пассивийн бүтцийг харуулбал:

График-17



#### 4.5. ҮЦК-иудын Ашигт ажиллагаа, орлого зардлын байдал:

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн нэгтгэл /нийт 52 ҮЦК/-ийн нийт орлого, зарлага, ашиг, алдагдал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-27 /төгрөгөөр /

№	Орлогын дэлгэрэнгүй тайлан 2015/12/31	Тайлант үе
1	Үйл ажиллагааны орлого	3,639,407,392.52
2	Ногдол ашгийн орлого	40,805,708.98
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	6,368,915,342.62
4	Ажиллагчдын цалингийн зардал	2,682,481,411.28
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	1,013,114,613.93
6	Санхүүгийн зардал	108,839,490.59
7	Бусад зардал	354,831,031.95
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-106,575,808.85
9	<b>Бусад ашиг (алдагдал)</b>	<b>-103,122,642.83</b>
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-604,182,963.06</b>
11	Орлогын татварын зардал	133,607,653.44
12	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-737,790,616.50</b>
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-737,790,616.50</b>
14	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00
15	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-737,790,616.50</b>
16	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>-348.38</b>

Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал нийт орлогын дүнгээс 1.7 дахин их буюу 2,688,702,241.12 төгрөгөөр илүү гарсантай холбоотойгоор 2015 оны эцсийн байдлаар системийн нэгтгэлийн үзүүлэлт 737,790,616.50 төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Системийн нэгтгэлийн үзүүлэлт алдагдалтай гарахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

**СЗХ | Үнэт цаасны зах зээлийн тойм /2015 оны 2 дугаар улирал/**

- Нэгтгэлд хамрагдсан 52 үнэт цаасны компаниас нэр бүхий 34 үнэт цаасны компани буюу 65.38 хувь нь алдагдалтай ажилласанба орлого зардлын харьцаа алдагдсан;
- Нэр бүхий 9 үнэт цаасны компани буюу 16.66 хувь нь 2015 онд арилжаанд оролцоогүй, шимтгэлийн орлого олоогүй тул түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал тус тус үүссэн байна.

**4.6. Нийт арилжааны дүн болон арилжаанд эзлэх хувь /компани бүрээр/**

2015 оны эцсийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн болох нийт 58 үнэт цаасны компаниудаас 46 компанийн нийт арилжаа нь оны эхнээс өссөн дүнгээр 582,541,273,218 төгрөг байх бөгөөд нийт арилжааны дүн болон эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-28 /төгрөгөөр/


№	Код	Компанийн нэр	Дүн	Хувь
1	TNGR	Тэнгэр капитал ХХК	222,590,624,700	38.21
2	TDB	Ти Ди Би Капитал ХХК	124,870,513,857	21.44
3	BDSC	БиДиСек ХК	51,604,281,821	8.86
4	ARD	Ард капитал групп ХХК	42,231,925,132	7.25
5	MSEC	Монсек ХХК	39,672,733,727	6.81
6	GLMT	Голомт секюритиз ХХК	39,439,622,608	6.77
7	NOVL	Новел инвестмент ХХК	28,326,501,868	4.86
8	STIN	Стандарт инвестмент ХХК	7,304,221,626	1.25
9	BZIN	Дэу Секьюритис Монгол	6,966,174,924	1.20
10	MIBG	Эм Ай Би Жи ХХК	3,526,255,817	0.61
11	DELG	Дэлгэрхангай секюритиз ХХК	2,978,428,404	0.51
12	LFTI	Лайфтайм инвестмент ХХК	2,279,717,600	0.39
13	ALTN	Алтан хоромсог ХХК	1,569,540,430	0.27
14	GDSC	Гүүдсек ХХК	1,346,999,160	0.23
15	MICC	Эм Ай Си Си ХХК	1,024,685,810	0.18
16	ARGB	Аргай бэст ХХК	929,662,675	0.16
17	GNDX	Гендекс ХХК	740,330,756	0.13
18	GATR	Гацуурт трейд ХХК	572,719,182	0.10
19	MONG	Монгол секюритиес ХК	553,468,370	0.10
20	BLMB	Блүмсбюри секюритиес ХХК	519,900,821	0.09
21	ZRGD	Зэргэд ХХК	455,399,321	0.08
22	TCHB	Тулгат чандмань баян ХХК	329,570,268	0.06
23	GAUL	Гаүли ХХК	306,641,396	0.05
24	BUMB	Бумбат-Алтай ХХК	280,423,205	0.05
25	SECP	СИКАП	262,944,610	0.05
26	SANR	Санар ХХК	229,120,195	0.04
27	DRBR	Дархан брокер ХХК	225,076,824	0.04
28	BULG	Булган брокер ХХК	220,368,609	0.04
29	APS	Азия Пасифик секьюритис ХХК	187,490,211	0.03
30	MSDQ	Масдак ХХК	159,485,419	0.03
31	TABO	Таван богд ХХК	157,394,437	0.03
32	FRON	Фронттиер ХХК	109,900,952	0.02
33	ACE	АСЕ энд Т Капитал ХХК	84,495,487	0.01
34	MERG	Мэргэн санаа ХХК	77,377,288	0.01
35	NSEC	Нэйшнл сэкюритис ХХК	72,835,896	0.01
36	ECM	Евразиа капитал монголиа ХХК	69,506,508	0.01
37	MNET	Ард секюритиз ХХК	66,825,088	0.01
38	UNDR	Өндөрхаан инвест ХХК	54,584,681	0.01
39	MWTS	Эм Даблью Ти Эс ХХК	43,384,286	0.01
40	ZGB	Зэт жи би ХХК	33,305,951	0.01
41	BSK	BLUE SKY	30,968,011	0.01

**СЗХ | Үнэт цаасны зах зээлийн тойм /2015 оны 2 дугаар улирал/**

42	SGC	Эс Жи Капитал ХХК	26,194,880	0.00
43	GDEV	Гранддевелопмент ХХК	5,240,255	0.00
44	FCX	Эф Си Икс ХХК	4,137,900	0.00
45	CAPM	Капитал маркет корпораци ХХК	270,000	0.00
46	BLAC	Блэкстоун интернэйшнл ХХК	22,254	0.00
47	BATS	Батс ХХК	0	0.00
48	BBSS	Би Би Эс Эс ХХК	0	0.00
49	BKHE	Бага хээр ХХК	0	0.00
50	DCF	Ди Си Эф ХХК	0	0.00
51	DGSN	Догсон ХХК	0	0.00
52	FINL	Финанс линк групп ХХК	0	0.00
53	GNN	ГОВИЙН НОЁН НУРУУ	0	0.00
54	HUN	Хүннү Эмпайр ХХК	0	0.00
55	ITR	Ай трейд ХХК	0	0.00
56	PREV	Превалент ХХК	0	0.00
57	TTOL	Таван Толгойн Хишиг	0	0.00
58	ZEUS	Зюс капитал ХХК	0	0.00
		<b>Нийт</b>	<b>582,541,273,218</b>	<b>100.00</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд 2015 оны эцсийн байдлаар арилжаанд нэр бүхий 12 үнэт цаасны компани огт оролцоогүй байх бөгөөд нэр бүхий 9 үнэт цаасны компани нийт арилжааны 1 хувиас дээшийг гүйцэтгэсэн байна. Үүнийг графикаар харуулбал.

График-18



**4.7. Хамгийн их ЗГҮЦ-ны арилжаа хийсэн ҮЦК**

Хүснэгт-29 /төгрөгөөр/

Д/д	БДК-ийн символ	БДК-ийн нэр	Нийт үнийн дүн
1	TNGR	Тэнгэр капитал ХХК	222,406,138,923
2	TDB	Ти Ди Би Капитал ХХК	85,821,472,620
3	BDSC	БиДиСек ХХК	42,526,258,899
4	ARD	Ард капитал групп ХХК	41,224,679,411
5	MSEC	Монсек ХХК	39,346,432,630
6	GLMT	Голомт секюритиз ХХК	38,464,437,219
7	NOVL	Новел инвестмент ХХК	28,320,296,513
8	BZIN	Дэу Секьюритис Монгол	6,940,521,484
9	STIN	Стандарт инвестмент ХХК	6,067,224,291
10	MIBG	Эм Ай Би Жи ХХК	3,490,245,817

**4.8. Хамгийн их хувьцааны арилжаа хийсэн ҮЦК**



Д/д	БДК-ийн символ	БДК-ийн нэр	Нийт үнийн дүн
1	TDB	Ти Ди Би Капитал ХХК	39,047,517,237
2	BDSC	БиДиСек ХК	9,011,922,922
3	DELG	Дэлгэрхангай секюритиз ХХК	2,978,208,404
4	LFTI	Лайфтайм инвестмент ХХК	2,279,717,600
5	STIN	Стандарт инвестмент ХХК	1,216,837,335
6	ARD	Ард капитал групп ХХК	1,007,245,721
7	GNDX	Гендекс ХХК	740,330,756
8	MONG	Монгол секюритиес ХК	553,468,370
9	ZRGD	Зэргэд ХХК	372,242,155
10	TCHB	Тулгат чандмань баян ХХК	329,570,268

#### 4.9. Кастодиан банкны тухай:

“Хаан банк” ХХК нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус Хорооноос 6 дугаар сард авсан ба 2015 оны эцсийн байдлаар тус Хорооноос кастодианы тусгай зөвшөөрөл авсан нийт 3 банк үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнийг Хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт-31

№	Компанийн нэр	Тогтоол-ын огноо	Тогтоолын дугаар
1	ГОЛОМТ БАНК	2014.08.27	295
2	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	2014.10.21	388
3	ХААН БАНК	2015.06.24	284

#### 4.10. Хөрөнгө оруулалтын сангийн тухай:

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан бөгөөд 2015 оны эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 367 дугаар тогтоолоор “Виртус рийл истейт ХОМК” ХХК-д хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмших зөвшөөрөл олгож, бүртгэсэн.

2015 онд гаргасан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэл						
№	Огноо	Үнэт цаас гаргагчийн нэр	Үнэт цаасны төрөл	Нэгж эрхийн үнэ	Нийт гаргасан үнэт цаасны тоо ширхэг	Нийт үнэлгээ
8	2015.09.25	"Виртус рийл истейт ХОМК" ХХК	Хувийн ХОС-ийн нэгж эрх	10,000₮	5,800,000	58,000,000,000₮

#### 4.11. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тухай:

Хорооноос 2015 оны жилийн эцсийн байдлаар нэр бүхий 7 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан.

Хүснэгт-32

№	Компанийн нэр	Тогтоол-ын огноо	Тогтоолын дугаар
1	"ЭКСПОНЭЙНШЛ ФАНД МЕНЕЖМЕНТ" ХХК	2014.04.23	129
2	"БОДЬ ИНВЕСТ" ХХК	2014.05.21	173
3	"ВИРТУС АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК	2014.12.10	433
4	"ГОЛОМТ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК	2015.11.23	402
5	"ГЛАШИЕР АССЕТ" ХХК	2015.11.23	403
6	"МАСТЕР ИНВЕСТМЕНТ МЕНЕЖМЕНТ" ХХК	2015.12.17	433
7	"ГЛОБАЛ ИНВЕСТМЕНТ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК	2015.12.17	439

#### 4.12. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа, төлбөр тооцооны үзүүлэлтүүд:

“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь 2015 онд нийт 6,877.0 тонн ноолуур, 10,170.8 тонн хонины ноос, 433.9 тонн тэмээний ноос, 1,411.8 тонн ямааны завод ноос, 719 тонн завод ноос, 1,576 тонн хүнсний буудайг нийт 431.7 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт-33 /төгрөгөөр/

№	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн
1	Ноолуур	6,877.0	383,756,728,600
2	Хонины ноос	10,170.8	17,829,893,000
3	Тэмээний ноос	433.9	2,352,650,000
4	Ямааны завод ноос	1,411.8	25,993,501,000
5	Завод ноос	718.6	887,020,000
6	Хүнсний буудай	1,576.0	872,610,000
	<b>Дүн</b>	<b>21,188.2</b>	<b>431,692,402,600</b>

График-19



Тус бирж нь 2015 онд шууд арилжих /spot/ гэрээгээр бараа, түүхий эдийн арилжааг явуулсан байна.

Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан бараа түүхий эдийн тус бүрийн үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулан дараах графикаар харуулав.

График-20 /сая төгрөгөөр /



Биржийн нийт арилжааг 2014 оны мөн үетэй харьцуулахад 22.04 хувиар бага байна. Энэ нь өмнөх өвөл манай орны нийт нутгаар дулаан байсантай холбоотой арилжааны голлох бараа ноолуурын ургалт муу, ширхэг богино байсан тул зах зээлийн үнэ ханш, үнэлгээ муу байхад нөлөөлсөн байна. Иймд түүхий эдийн чанараас шалтгаалж нийт арилжааны хэмжээ мөн бага байхад нөлөөлсөн гэсэн дүгнэлт өгч болохоор байна.

Харин 2015 оны хавраас эхэлж биржээр Хүнсний буудай арилжаалж эхэлсэн ба Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.10-д “Энэ хуулийн 4.5, 5.1.7-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна” гэж заасны дагуу төсвийн хөрөнгөөр улаан буудай худалдан авалт хийх тохиолдолд биржээр дамжуулснаар арилжааны хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлт байна. Мөн биржийн арилжааны хэмжээг нэмэгдүүлж, зах зээлийг өргөжүүлэхийн тулд арилжаалагдах бараа, түүхий эдийн төрлийг олшруулах шаардлагатай байна.

Тус бирж дээр 2015-2016 онуудад бараа, түүхий эдэд суурилсан нэг загварын гэрээ /фьючерс/-ний арилжааг эхлүүлэхээр биржийн зүгээс холбогдох бэлтгэл ажлуудыг хангасан ба арилжааны цахим систем /платформ/-ийг худалдан авах санхүүжилт саатсантай холбоотой уг ажил 2015 оны эцсийн байдлаар хэрэгжиж эхлээгүй байна.

#### **4.13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой бүртгэл, зохицуулалт:**

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10-р сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-2/06 тоот тушаалаар “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг баталсан.

Энэхүү дэд хөтөлбөрт ипотекийн хоёрдогч захыг хөгжүүлэх эхний үе шатанд санхүүгийн эх үүсвэрээр хангах, ипотекийн хоёрдогч захад үйл ажиллагаа явуулах үндсэн санхүүгийн байгууллагыг бодлого зохицуулалтаар дэмжих арга, хэрэгслээр 3 жилийн хугацаанд, 800.0 тэрбум төгрөгийн санхүүжилттэй хэрэгжүүлэх “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр” багтсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-т “Монголбанкны эзэмшиж байгаа ипотекоор баталгаажсан үнэт цаастай тэнцэх хэмжээний урт хугацаат үнэт цаасыг Засгийн газар эдийн засгийн чадавхид тулгуурлан нийгмийн даатгалын санг дахин хөрөнгөжүүлэх зорилгоор хэсэгчлэн гаргана.

Засгийн газар Монголбанкны эзэмшиж байгаа ипотекоор баталгаажсан үнэт цаасыг дахин хөрөнгөжсөн Нийгмийн даатгалын сангийн активт хөрвүүлнэ. Мөн Монголбанк ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох эхлэлийн санхүүжилтийг шийдвэрлэнэ” гэж тусгасан.

Эдгээр санамж бичиг, хөтөлбөрүүдийн хүрээнд Монголбанкнаас “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам” баталж, мөн Монголбанк, арилжааны банкууд, “МИК ОССК”-ийн хооронд “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан байна.

Гэрээнд Монголбанк ипотекийн хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эхлэлийн санхүүжилтийг “Монголбанкнаас банкинд олгох орон сууцны ипотекийн санхүүжилтийн гэрээ”-г байгуулан олгох, банк нь орон сууцны ипотекийн зээлийг “МИК ОССК”-иас үүсгэн байгуулсан ТЗК-д худалдах, тухайн ТЗК-иас гаргасан ИЗББ-ыг худалдан авах хэлцлийг МИК болон банкны

хооронд байгуулах гэрээний дагуу хийнэ гэх зэрэг ерөнхий зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагын талаар тусгасан.

Дээрх хөтөлбөрүүд, санамж бичиг болон гэрээний хүрээнд орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажлыг гүйцэтгэхэд эрх зүйн зохицуулалт, дүрэм журамд өөрчлөлт оруулах, шинээр журам тогтоох шаардлага үүссэн.

Монголбанк болон “МИК ОССК”-ийн зүгээс Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-д өөрчлөлт оруулах саналыг ирүүлсэн бөгөөд тус Хорооны зүгээс уг журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг бэлтгэж, хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, холбогдох өөрчлөлтийг оруулсан.

Эдгээр эрх зүйн орчин бүрдсэнээр “МИК ОССК” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий өөрийн бүрэн эзэмшлийн тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны болон хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан.

Мөн Хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 417 дугаар тогтоолоор “МИК ОССК” ХХК-д нээлттэй компани болон хэлбэрээ өөрчилөхийг зөвшөөрч нэр бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртдэлд бүргэсэн.

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий 7 тусгай зориулалтын компаниуд нь нийт 47,495 зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан 2,171,745,920,000 төгрөгийн үнэ бүхий баталгаат үнэт цаас гаргасан. 2015 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 160,290,000,000 төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн байна.

Хүснэгт-34

Үнэтцаасгаргагч	Нийт гаргасан баталгаат үнэт цаас /тэрбум.төг/	"ҮЦТТТХТ" ХХК-д бүртгэсэн үнэт цаас /тэрбум.төг/	Зээлдэгчдийн тоо 2015.12.31-ний байдлаар
“МИК активнэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,896
“МИК активхоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,433
“МИК активгурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,747
“МИК активдөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,684
“МИК активтав ТЗК” ХХК	301.2	294.3	5,904
“МИК активзургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,244
“МИК активдолоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,450
<b>Нийт</b>	<b>2,209.4</b>	<b>2,171.7</b>	<b>45,358</b>

Хүснэгт-35

№	Компанийн нэрс	Хорооны тогтоолын дагуу	"ҮЦТТТХТ" ХХК бүртгэсэн	2015.12.31-ний үлдэгдэл	Төлөгдсөн үндсэн төлбөр		
1	“МИК актив нэг ТЗК” ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	328,146,500,000 төгрөгхүртэл	2013.12.16-ны өдрийн 512	322,901,700,000	267,201,700,000	55,700,000,000
		Зээлдэгчдийн тоо	7,917		7,853	6,896	-
2	“МИК актив хоёр ТЗК” ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	224,836,200,000 төгрөг хүртэл	2014.06.25-ны өдрийн 243	222,051,700,000	177,651,700,000	44,400,000,000
		Зээлдэгчдийн тоо	5,937		5,898	5,433	-
3	“МИК актив гурав ТЗК”	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	328,548,600,000 төгрөг хүртэл	2014.10.21-ний өдрийн 386	324,595,800,000	284,995,800,000	39,600,000,000

	<b>ХХК</b>	Зээлдэгчдийн тоо	7,105		7,059	6,747	-
4	<b>“МИК актив дөрөв ТЗК” ХХК</b>	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	459,372,600,000 төгрөг хүртэл	2015.01.14-ний өдрийн 18	452,278,100,000	448,288,100,000	3,990,000,000.0
		Зээлдэгчдийн тоо	10,034		9,961	9,684	-
5	<b>“МИК актив тав ТЗК” ХХК</b>	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	301,213,000,000 төгрөг хүртэл	2015.03.14-ний өдрийн 18	294,343,300,000	277,743,300,000	16,600,000,000
		Зээлдэгчдийн тоо	6,052		5,997	5,904	-
6	<b>“МИК актив зургаа ТЗК” ХХК</b>	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	267,809,600,000 төгрөг хүртэл	2015.08.05-ны өдрийн 337	261,699,200,000	261,699,200,000	-
		Зээлдэгчдийн тоо	5,329		5,227	5,244	-
7	<b>“МИК актив долоо ТЗК” ХХК</b>	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	299,674,400,000 төгрөг хүртэл	2015.11.23-ны өдрийн 386	293,876,120,000	293,876,120,000	-
		Зээлдэгчдийн тоо	5,500		5,500	5,450	-
8	<b>НИЙТ</b>	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төг/	2,209,600,900,000	-	2,171,745,920,000	2,011,455,920,000	160,290,000,000
		Зээлдэгчдийн тоо	47,874	-	47,495	45,358	-

**4.14. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө өгөх, хөрөнгийн үнэлгээ хийх, аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээдүүдийн талаарх мэдээлэл:**

Санхүүгийн зохицуулах хороо 2015 оны эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын, үнэлгээний, хуулийн үйлчилгээ үзүүлэх нийт 73 компанийг бүртгээд байна. Үүнд:

Хүснэгт-36

№	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын тоо
1	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудитын компани	36
2	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компани	20
3	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компани	17
	<b>НИЙТ</b>	<b>73</b>

**4.15. Өөрийгөө зохицуулах байгууллагатай холбоотой:**

Өөрийгөө зохицуулах байгууллага нь зохицуулалттай хуулийн этгээд болон үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилготой билээ. Мөн өөрийгөө зохицуулах байгууллага бий болсноор төр, хувийн хэвшлийн түншлэл сайжрах, зах зээлийн хяналт нэмэгдэх, мэргэжлийн оролцогчдын ёс зүй сайжрах зэрэг давуу талуудтай юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Өөрийгөө зохицуулах байгууллагын бүртгэх тухай журам” батлагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо /МУЦАЭХ/” ТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг тус тус өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэхээр шийдвэрлэсэн.

## 5. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ АЗИЙН УЛС ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.

### 5.1.Хөрөнгийн зах зээлийн зарим үзүүлэлт /Азийн улсууд/:

Хүснэгт-37

№	Улс	Зах зээлийн үнэлгээ ДНБ-д эзлэх хувь	Арилжааны дүн ЗЗҮ-д эзлэх хувь (хөрвөх чадвар)
1	Монгол	7%	1.7%
2	Вьетнам	24%	55%
3	Индонез	52%	31%
4	Тайланд	113%	80%
5	Сингапур	256%	26%
6	Өмнөд Солонгос	79%	82%
7	Япон	104%	120%

Манай орны хөрөнгийн зах зээлийн сул хөгжлийн улмаас эдийн засагт дараах сөрөг үр дагаврууд бий болж байна:

1. Бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих урт хугацаат, хүү багатай санхүүжилтийн суваг хязгаарлагдмал байна. Арилжааны банкуудын бизнесийн зээлийн дундаж хүү 22%, хугацаа нь 36 сар байгаа өнөөгийн нөхцлийг өөрчилж, шинэ санаа, инновациуд урт хугацаатай санхүүжилт босгодог болох үндсэн нөхцөл нь Үнэт цаасны зах зээлийн хөгжил юм.
2. Эдийн засгийн өсөлтийн хүртээмж бага байна. Өмч хувьчлалын үеэр үүссэн болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшихээр бүртгүүлсэн дансуудыг тооцвол манай иргэн бүр шахуу үнэт цаасны данстай боловч тэдгээрийн ердөө 1% нь арилжаанд идэвхитэй оролцдог. Өөрөөр хэлбэл томоохон хувьцаат компаниудын ашиг орлогын болон зах зээлийн үнэлгээний өсөлт олон түмэнд хүртээлгүй, өргөн утгаар нь харвал эдийн засгийн өсөлтийн хүртээмж хүмүүст хүрч, дундаж давхарга бий болох нөхцөл бүрдээгүй байна.

Санхүүгийн системийн эрсдэл өндөр, валютын орох урсгал гадаадын шууд хөрөнгө оруулалт, цөөн тооны экспортын бүтээгдэхүүний орлого гэсэн хоёрхон сувагтай. Мэргэшсэн хөрөнгө оруулагчид, тэдгээрийн эрсдлийг бууруулах санхүүгийн хэрэгслүүд байхгүйгээс санхүүгийн системийн нийт эрсдэл банкны салбар буюу тэдгээрийн хадгаламж эзэмшигчдийн нуруун дээр төвлөрч байна. Валют урсгал буюу мөнгөн хөрөнгө гаднаас орж ирэх гол суваг болсон санхүүгийн хөрөнгө оруулалт маш бага /3 тэрбум ам.доллар/ (Монгол банк, 2015), гадаадын хөрөнгө оруулалт зөвхөн шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр /16 тэрбум ам.доллар/ орж ирж байна. Харьцуулбал хөгжингүй орнуудад гадаадын нийт хөрөнгө оруулалтын 60 гаруй хувь нь санхүүгийн хөрөнгө оруулалт, үлдэх 40 орчим хувь нь шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр ордог байна. (McKinsey Global Institute , 2013)

### 5.2. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц, зохицуулалт:

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үр ашигтай, найдвартай, хурдан шуурхай байдал нь хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлд, хөгжилд голлогч нөлөөллийг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн бирж дээр хийгдсэн хэлцлийн дүнд үнэт цаасны өмчлөх эрх, мөнгөн хөрөнгө хурдан шуурхай шилжүүлэх асуудал зах зээлийн дэд бүтцийн уялдаа, технологийн хөгжлөөс ихээхэн хамаардаг.

1995 оноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдэж эхэлсэн бөгөөд 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд “Бодь”

ХХК-ийн охин компани “ЕСМ” ХХК-ийн боловсруулсан арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн програм хангамжийг ашиглаж ирсэн.

“Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК-ууд 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс арилжаа, тооцоо, хадгаламжийн МІТ системийг албан ёсоор ашиглаж эхэлсэн. МІТ систем нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын ажиллагааг дэмжсэн, их хэмжээний хэлцлийг нэг зэрэг, цаг хугацааны хоцролтгүй биелүүлэх, маржин ба зээлээр үнэт цаас худалдах, худалдан авах, кастодианы дэд програмыг агуулснаараа давуу талтай.

Зураг-1.




Гэвч үнэт цаасны арилжааны тооцооны бие даасан дундын зуучлалын үйлчилгээ манайд бий болоогүй, нэгдсэн програм хангамжийг хөгжүүлж чадахгүй байгаагаас санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон зээлээр үнэт цаас худалдах, худалдан авах маржин арилжааг бий болгоход шаардлагатай үнэт цаасны төлбөр тооцооны баталгаажуулалтад бэрхшээл үүсч байна.

Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоолоор “ҮЦТТТХТ” ХХК-ийг төлбөр тооцооны, төвлөрсөн хадгаламжийн чиглэлээр 2 тусдаа бие даасан байгууллага бий болгохоор шийдвэрлэсэн бөгөөд цаашид үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулахад арилжааны тооцооны чиглэлээр байгуулагдах шинэ байгууллагыг Үндэсний цахим гүйлгээний үндэсний төвд түшиглэн бие даасан дундын зуучлалын төвийг шинээр байгуулах, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг хувьчлах нь зүйтэй байна.

Бие даасан дундын зуучлалын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэн үнэт цаас, хөдөө аж ахуйн, уул уурхайн биржүүдийн арилжааны тооцоог гүйцэтгэх чиглэлд өргөтгөх, кастодианы үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх зэрэг дэд бүтцийн ажлын уялдааг хангах талаар ажиллах шаардлага бий болоод байна.

Цаашдын дэд бүтцийн хандлагын төслийг схемээр үзүүлбэл:

**Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн хандлага**



**6. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД 2015 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОЙМ.**

**6.1. Хорооноос 2015 онд Үнэт цаасны зах зээлд мөрдүүлэхээр баталсан дүрэм журам, бодлогын баримт бичиг:**

ҮЦЗГ-аас 2015 онд нийт 12 журам, зааврын төсөл, нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан байх ба зохих журмын дагуу санал авч, 9 журам, зааврын төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд:

1. 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Хорооны хуралдаанаар “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-д өөрчлөлт оруулсан.
2. Хорооны 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2015 оны 11 сарын 23-ны өдрийн Хорооны хурлаар журмыг шинэчилэн баталсан.
3. Хорооны 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам”-ыг шинэчилэн баталсан.
4. Хорооны 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар “Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, НББ хөтлөх, цэвэр хөрөнгө үнэлэх заавар”-ыг хэлэлцүүлсэн.
5. Хорооны 2015 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, 328 дугаар тогтоол гаргасан.
6. Хорооны 2015 оны 8 дугаар сарын 05-ны хуралдаанаар “Кастодианы санхүүгийн тайлагнал бэлтгэх, НББ хөтлөх заавар”-ыг баталсан.
7. Хорооны 2015 оны 8 дугаар сарын 05-ны хуралдаанаар “Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, НББ хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар”-ыг баталсан.



8. “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих тухай журам”-ыг 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар баталсан.
9. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар шинэчилэн баталсан. Уг журмын хүрээнд нийтэд санал болгон хувьцаа, бонд гаргахтай холбоотой хяналтын чиг үүрэг болон бүртгэлтэй холбоотой шалгуур, шаардлага тогтоох бүрэн эрхийг арилжаа эрхлэх байгууллагад бүрэн шилжүүлсэн. Ингэснээр арилжаа эрхлэх байгууллага нь өөрийн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүнийг бүртгэх зөвшөөрлийг олгох бөгөөд үнэт цаас гаргахтай холбоотой хяналт, шалгалтын давхардал багасаж, бүртгэлтэй холбоотой ажилбарт зарцуулагдах цаг хугацаа өмнөхөөс 2 сар буюу 50 хувиар богиносгов.
10. "Зохицуулалттай зарим этгээдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ыг Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар шинэчилэн баталсан. Уг журмын хүрээнд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулж, цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, зөвшөөрлийн маягтыг зөвшөөрөл хүсэгчдэд энгийн ойлгомжтой болгож, олон улсын жишигт нийцүүлсэн. Мөн зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх асуудлуудыг тодорхой зохицуулсан.
11. “Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар”-ыг Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар шинэчилэн баталсан.

Шинээр боловсруулсан журмууд:

1. “Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар”
2. “Кастодианы санхүүгийн тайлагнал бэлтгэх, НББ хөтлөх заавар”
3. “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанид онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”
4. “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих тухай журам”
5. “Үнэт цаасны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журам
6. "Хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам"

## **6.2. Зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлээр:**

2015 онд Хорооноос үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Хорооны 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн бирж дээр арилжаа хийгдсэн өдрөөс хойш дараагийн ажлын өдөрт багтаан тухайн хэлцлийн буюу үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэж байхаар тогтоосон.
2. Хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01, 2015 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчдөөс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний журам”-ыг шинэчлэн хувь хэмжээг бууруулан батлаж, зарим зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөхийг 2 жилийн хугацаагаар зогсоохоор шийдвэрлэсэн 158, 159 дүгээр тогтоолыг гаргасан.
3. Дээрх ажлын мөрөөр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас хувьцааны арилжааны шимтгэлийн хувийг 3 сарын хугацаатай 0.15 хувь болгон бууруулсан.
4. Хорооноос “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т үнэт цаасны зах зээлд оролцогчдын саналыг тусгасны үндсэн дээр боловсруулж баталсан.

5. 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр МҮХАҮТ-ын хурлын танхимд үнэт цаасны зах зээлд гарах боломжийн талаар өдөрлөг зохион байгуулж, нийт 150 гаруй оролцогчдыг хамруулсан.
6. Хорооны 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар “МҮЦАЭХ-г өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэх” асуудлыг шийдвэрлэсэн.  
Хорооны 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэх асуудлыг шийдвэрлэсэн.
7. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 292 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны тухай асуудлыг тус тус хэлэлцүүлж 02 тоот зөвлөмж, 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын 147 дугаар тогтоол гаргуулсан. Уг шийдвэрийн үр дүнд үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн гол байгууллага болох арилжааны тооцооны төв буюу дундын зуучлалын төвийг байгуулагдах боломж бүрдлээ. Мөн "Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны журам"-ын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авах ажлыг хийсэн.
8. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар "Үнэт цаасны зах зээлийг идэвхижүүлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын төслийг хэлэлцүүлж, 13 дугаар тогтоолыг гаргуулсан. Тогтоолд "Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны ажлын уялдаа, хамтын ажиллагааг идэвхижүүлэх, санхүүгийн салбарын болон үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудалтай холбоотой аливаа харилцаанд Санхүүгийн зохицуулах хорооны оролцоог хангаж, дүрэм, журам, гэрээ, хэлэлцээр, баримт бичигт түүний санал, дүгнэлтийг авч ажиллах" зэрэг 9 заалт тусгагдсан бөгөөд Хорооны болон Үнэт цаасны зах зээлийн хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой шийдвэр болсон.

### **6.3. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын чиглэлээр**

1. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 292 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны тухай асуудлыг тус тус хэлэлцүүлж 02 тоот зөвлөмж, 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын 147 дугаар тогтоол гаргуулсан. Уг шийдвэрийн үр дүнд үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн гол байгууллага болох арилжааны тооцооны төв буюу дундын зуучлалын төвийг байгуулагдах боломж бүрдсэн.
2. Биржийн арилжааны дараах үнэт цаасны тооцооны байгууллагын үйл ажиллагааны бүтэц, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр судалгааны ажлыг хийж, "Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журам"-ын төслийг боловсруулсан.
3. Хорооны 2015 оны 12 сарын 17-ны өдрийн хуралдаанаар хувьчлалын жагсаалтад орсон "Монгол шуудан" ХК-ийн 33,8 сая ширхэг нэмж гаргах хувьцааг бүртгэх асуудлыг хэлэлцүүлэн 416 дугаар тогтоолоор баталсан.
4. Үнэт цаасны зах зээлд ашиглаж байгаа програм хангамжийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, “Майти” системийг цаашид боловсронгуй болгож, уг систем нь зах зээлийг хөгжүүлэхэд саадгүй ажиллаж байх нөхцөлийг бүрдүүлэх шуурхай арга хэмжээ авах асуудлаар Хорооны зүгээс санал боловсруулан хүргүүлсэнээр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоолыг гаргуулсан.
5. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай асуудлыг Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 151 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын дагуу Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлт гаргасан боловч хувьцааны төлбөр авч чадаагүй буюу хишиг хувь хүртээгүй 1 503 984 иргэдэд 1 583 628 456 ширхэг хувьцааг нь буцаан эзэмшүүлээ.

6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд холбогдох саналыг, хуулийн төслийн хамт боловсруулж, "Санхүүгийн зах зээлийн 2025 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр"-т тусгасан.
7. Төрийн өмчит 11 компанийн хувьчлалтай холбоотойгоор хөрөнгийн зах зээл, компанийн засаглал, гадаад болон дотоодын зах зээлд дээр IPO хийх ажиллагаа болон бүртгэлтэй компанийн дагаж мөрдөх шаардлагатай дүрэм, журмын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор нийт гурван удаагийн сургалт, семинарыг Японы ЖАЙКА байгууллага, МҮХАҮТ, Төрийн өмчийн хороотой хамтран компанийн эрх бүхий албан тушаалтанд зориулан нийт 200 гаруй оролцогчдыг хамруулан зохион байгуулсан.
8. Люксембургийн вант улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр Мон004 төслийн хүрээнд Үүсмэл санхүүгийн зах зээлийг бий болгох эрхзүйн орчныг бүрдүүлэх эхлэлийг тавьж, "Үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх" журмын төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Энэ төслийн хүрээнд 2016 онд үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах, тухайлбал арилжаа эрхлэх байгууллагад шинэ бүтээгдэхүүн гаргах, хөгжүүлэх ажлууд хэрэгжинэ.

#### **6.4. Зах зээлийн үйлчилгээ, сургалт, сурталчилгааны чиглэлээр**

1. Хорооны даргын 2015 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тушаалаар мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилуулсан. Уг Мэргэшлийн зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хуралдааныг зохион байгуулж, үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах мэргэжилтэнд эрх олгох шалгалтыг зохион байгуулсан.
